



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 11/549

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн Эрүүл
мэндийн төвийн балансаас
хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 102,480,231.61 /нэг зуун хоёр сая дөрвөн зуун наян мянга хоёр зуун гучин нэгэн төгрөг, жаран нэгэн мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв /З.Балдандугар/-д зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв /Д.Шинэбаяр/-д даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв /З.Балдандугар/, Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв /Д.Шинэбаяр/-д тус тус үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050001473

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 12 дугаар
сарын 11 өдрийн А/ тоот тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвөөс Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвд

№	Эд хогшлын нэр	Марк үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Ашиглалтад авсан он	Нэгж үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл /2019.09.30/	Нийт үлдэгдэл /2019.09.30/
1	Хөлний шахалтын дасгалын хэрэгсэлт	GX-310	ш	1	2018	16,561,602.15	16,561,602.15	3,450,333.80	13,111,268.35
2	Дээд, доод мөчний булчингийн хүч сайжруулах дасгалын хэрэгсэл	GX-300	ш	1	2018	13,406,232.95	13,406,232.95	3,723,953.60	9,682,279.35
3	Түнхний үений дасгалын хэрэгсэл	GX-330	ш	1	2018	13,776,856.58	13,776,856.58	2,870,178.42	10,906,678.16
4	Хөл булчингийн хүч сайжруулах дасгалын хэрэгсэл	GX-320	ш	1	2018	15,075,034.43	15,075,034.43	3,140,632.20	11,934,402.23
5	Автомат босгогч ор	UA-SO1-S3	ш	1	2018	20,947,534.21	20,947,534.21	4,364,069.60	16,583,464.61
6	Паралель бар	GH-2650	ш	1	2018	5,850,827.64	5,850,827.64	1,218,922.40	4,631,905.24
7	Дасгалын шат	GH-455	ш	1	2018	7,197,316.59	7,197,316.59	1,499,440.98	5,697,875.61
8	Өргөгч бүхий хөдөлгөөн засал, эмчилгээний ор	GH-730	ш	1	20148	9,664,827.06	9,664,827.06	2,013,505.62	7,651,321.44
Тоног төхөөрөмжийн дүн				8			102,480,231.61	22,281,036.62	80,199,194.99